



ИРГЭНИЙ ҮҮРГИЙН ОНОЛЫН ФИЛОСОФИ, ЭРХ ЗҮЙН ҮНДЭС: АНГИЛАЛ, ЧИГ ХАНДЛАГА

THE PHILOSOPHICAL AND LEGAL FOUNDATIONS OF CIVIC DUTIES: CLASSIFICATION AND CONTEMPORARY TRENDS

Тойвгоо Түвшинжаргал¹

Shihihutug University, E-mail: tuvshinjargal@shihihutug.edu.mn <https://orcid.org/0009-0005-7514-2622>

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

ХУРААНГУЙ

Түлхүүр үгс:

Иргэний үүрэг, Үндсэн хуулийн үүрэг, Эрх ба үүргийн харилцан хамаарал, Нийгмийн гэрээний онол, Иргэний оролцоо, Хариуцлагатай иргэн, Ардчилсан засаглал

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2026, 03 сар
Шинэчилсэн: 2026, 03 сар
Хүлээн зөвшөөрсөн: 2026, 04 сар

eywords:

Civic Duties, Constitutional Duties, Correlation of Rights and Duties, Social Contract Theory, Civic Participation, Responsible Citizenship, Democratic Governance

Article history:

Received March, 2026
Revised March, 2026

Орчин үеийн Үндсэн хуулийн эрх зүйн хөгжил нь хүний болон иргэний эрхийг өргөн хүрээнд баталгаажуулж, тэдгээрийг институцилэх чиглэлд голлон төвлөрч ирсэн байна. Хүний эрхийн олон улсын стандарт болон үндэсний Үндсэн хуулиудын хөгжлийн явцад эрхийн хамгаалалт өргөжиж, иргэнийг төрийн хэт оролцооноос хамгаалах механизм боловсронгуй болсон хэдий ч энэ үйл явц нь иргэний үүргийн агуулга, түүний эрх зүйн болон институцийн байр суурийг харьцангуй орхигдуулахад хүргэсэн байна. Үүний улмаас нийгэмд эрх, үүргийн тэнцвэргүй байдал бий болсон талаар судлаачид онцлох болжээ.² Эрх, үүргийн харилцаа нь онолын хувьд харилцан хамааралтай, салиггүй шинжтэй боловч практикт эрхийг өргөтгөх, үүргийг хязгаарлах хандлага давамгайлж байгаа нь төр, иргэний харилцаанд хариуцлагын тэгш бус байдал үүсгэх нөхцөл болдог. Иргэний үүрэг нь эрхийн эсрэгцэл бус, харин түүнийг нөхцөлдүүлэгч, баталгаажуулагч элемент бөгөөд иргэний үүргийг онол, хууль зүй, практикийн уялдаанд судлах нь нийгмийн тогтвортой байдал, хууль ёсны хэрэгжилт, ардчиллын баталгаанд онцгой ач холбогдолтой юм.

The development of modern constitutional law has primarily focused on guaranteeing and institutionalizing human and civil rights. Throughout the evolution of international human rights standards and national constitutions, the scope of rights protection has expanded considerably, and legal mechanisms designed to protect individuals from excessive state interference have become increasingly sophisticated. However, this process has also contributed to the relative neglect of the concept of civic duties and their legal and

¹ Шихихутуг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах ажилтан, магистрант

² Mila Versteeg, Adam Chilton, Erensu Altan, "Constitutional Duties" University of Chicago Law School, Public Law & Legal Theory Research Paper No. 25-15 https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=5104694#

Accepted April, 2026

institutional status. As a result, scholars have increasingly pointed to the emergence of an imbalance between rights and duties within contemporary societies.

From a theoretical perspective, rights and duties are inherently interdependent and inseparable. In practice, however, the prevailing tendency has been to expand the scope of rights while limiting or overlooking civic obligations. Such an approach may create an imbalance of responsibility in the relationship between the state and citizens, potentially undermining the foundations of constitutional governance and social cohesion.

Civic duties should not be understood as the antithesis of rights; rather, they constitute an essential element that conditions, supports, and guarantees the effective realization of rights. Duties provide the normative and institutional framework within which rights can be exercised and protected. Consequently, the study of civic duties from theoretical, legal, and practical perspectives is of particular importance for ensuring social stability, the effective implementation of the rule of law, and the sustainability of democratic governance. A comprehensive understanding of civic duties therefore contributes not only to constitutional theory but also to the strengthening of responsible citizenship and the preservation of a balanced relationship between rights and obligations in a democratic society..

Энэ өгүүлэл CC BY-NC лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



1. Танилцуулга

Үүрэг (лат. officium, obligatio) хэмээх ойлголт нь анх эртний Ромын эрх зүй болон эрх зүйн философийн түвшинд бүтэцжсэн гэж үздэг. Эртний Ромын хуульч Цицерон “Үүргийн тухай” (De Officiis, НТӨ 44 он) бүтээлдээ “officium” буюу иргэн, төр, хүний нийгэмд хүлээсэн ёс суртахууны болон хууль ёсны зөв үүргийг анх системтэйгээр томъёолж, “Үүрэг нь нийтийн ашигт, шударга, зохистой үйлдэл юм” хэмээн тодорхойлсон³ байна.

Монгол хэлний их тайлбар тольд⁴ “үүрэг” нь нэр үг бөгөөд үйл хариуцах, даалгавар гүйцэтгэх, хариуцлага үүрэх үйл үгийн утгыг агуулдаг төдийгүй “үүрэх” буюу ачаа үүрэх, хариуцлага хүлээх гэсэн язгуураас гаралтай биеэр болон ухамсраар хариуцах, даах гэсэн санааг илэрхийлдэг.

Монгол Улсад иргэний үүргийг Үндсэн хуулийн арван долдугаар зүйлд

1. Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:

1/Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;

2/хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

3/хуулиар ногдуулсан албан татвар төлөх;

³ Cicero, *De Officiis*, I.4.

⁴ Монгол хэлний их тайлбар толь. <https://mongoltoli.mn/>

4/эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.

2.Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн гэж заажээ.

Эдгээр иргэний үндсэн болон журамт үүргүүд нь зөвхөн тодорхой үйлдлийг заавал гүйцэтгэх эрх зүйн шаардлага бус, харин иргэн ба нийгмийн харилцаанд “хариуцлагын тэнцвэр”-ийг бий болгох олон давхар агуулгатай зохицуулалт юм.

2. Арга зүй

Иргэний үүргийг зөвхөн формаль эрх зүйн арга зүйгээр хязгаарлах боломжгүй бөгөөд норматив үнэт зүйн арга зүйн үүднээс нийгмийн зорилго, үнэт зүйлсийн ач холбогдлоор нь, системийн арга зүйн үүднээс иргэний үүргийг харилцан уялдаа бүхий систем гэж үзэж, эрх үүргийн корреляцийг тодорхойлох зорилгоор; функциональ арга зүйн хүрээнд үүрэг бүр нийгэмд ямар үүрэг гүйцэтгэж байгаагаар нь (аюулгүй байдал, байгаль орчноо хайрлан, хамгаалах, дэг журам, хөгжил гэх мэт); харьцуулсан судалгааны арга зүйн хүрээнд өөр өөр улс орны эрх зүйн зохицуулалт, соёлын онцлогийг харьцуулан судлах зорилгоор ангилах зэргээр олон талт арга зүйг ашиглан ангилах замаар үүргийн мөн чанарыг тодорхойлох боломжийг судлав.

3. Судалгааны үр дүн

Эрх зүйн онолын үүднээс иргэний үүргийг иргэнээс нийгэм, төрийн өмнө хүлээх ёстой хариуцлага, зан үйлийн норматив шаардлага гэж тодорхойлдог бөгөөд түүний мөн чанарыг судлаачид дараах гурван түвшинд авч үздэг:

- Тухайн улсын хууль тогтоомжид заасан заавал биелүүлэх зан үйлээр илэрнэ гэж үздэг хууль зүйн үүрэг;
- Нийгмийн хүлээлт, үнэт зүйлд суурилсан хариуцлагаар илэрнэ гэж үздэг ёс суртахууны үүрэг;
- Төрийн легитим чанарыг хангах, оролцооны хэлбэр гэж үздэг улс төрийн үүрэг.

Эндээс нэгтгэн үзвэл иргэний үүрэг нь зөвхөн хууль зүйн ойлголт бус, харин философи, улс төр, нийгмийн хэм хэмжээний системийн олон талт ойлголт байна.

Үүргийг ойлгох философийн сонгодог онолуудаас авч үзвэл: Улс төр, эрх зүйн философийн хүрээнд иргэний үүргийн ойлголтыг Нийгмийн гэрээний онол болон Ёс суртахууны онолуудаар системтэй боловсруулж иржээ.

Нийгмийн гэрээний онол (Social Contract Theory): Ж.Локк, Ж.Ж.Руссо Т.Хоббс нарын үзсэнээр хүмүүс байгалиасаа хязгааргүй эрх чөлөөтэй байсан ч аюулгүй байдал, шударга ёс, хамтын ашиг сонирхлын үүднээс өөрийн эрхийн тодорхой хэсгийг сайн дурын үндсэн дээр хязгаарлан төрд шилжүүлж, хариуд нь төр хамгаалалт, дэг журмыг баталгаажуулах харилцан үүрэг хүлээнээр иргэний үүрэг нь төр-иргэн хоорондын гэрээний үүргийн биелэл, нийгмийн гэрээний ёс зүйн ба эрх зүйн илэрхийлэл болж байдаг.

Томас Хоббс (*Leviathan*, 1651)⁵ байгалийн төлөв дэх эмх замбараагүй байдлыг зогсоохын тулд хүмүүс харилцан гэрээ байгуулж, дээд эрх мэдэл бүхий “Левиафан”

⁵ T.Hobbes's *Leviathan*, <https://historyofeconomicthought.mcmaster.ca/hobbes/Leviathan.pdf>

буюу төрийг бий болгосон бөгөөд иргэний үүргийг аюулгүй байдлын төлөө төрд захирагдах зайлшгүй шаардлага (хууль сахих, татвар төлөх) гэж үзсэн.

Жон Локк (*Two Treatises of Government*)⁶ Хүн байгалийн төлөвт эрх чөлөөтэй, өмчтэй байх төрөлхийн эрхтэй ч тэрхүү эрхээ хамгаалахын тулд төр байгуулах шаардлагатай болсон. Төр нь зөвхөн иргэний амьдрал, эрх, өмчийг хамгаалах үүрэгтэй, харин төр үүргээ биелүүлэхгүй бол иргэн төрийг үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй гэж үзсэн. Локкийн хувьд иргэний үүрэг нь төрийн хууль ёсны эрх мэдлийг дэмжих, эрхээ эдлэхдээ бусдын эрхийг хүндэтгэх явдал юм хэмээн үүргийг эрхийг хамгаалах нөхцөлтэй холбон тайлбарласан байна.

Ёс суртахууны онол (Деонтологи, Утилитаризм, Сайн чанарын ёс зүй): Ёс суртахууны онол нь иргэний үүргийг хүний дотоод ухамсар, үнэт зүйл, нийгмийн хариуцлагад тулгуурласан ёс зүйн үзэгдэл хэмээн тайлбарладаг. XVIII зуунд Иммануэл Кант үүргийг ёс зүйн төв ойлголт болгон хөгжүүлж⁷, хүний үйлдлийн ёс суртахууны үнэлэмж үүрэгт тулгуурлана гэж үзээд “Moralität ist Handeln aus Pflicht” буюу “Ёс суртахуун гэдэг бол үүргээс үүдэн үйлдэх явдал юм” гэж үзсэн.⁸ Кантын деонтологийн онолд үүрэг нь “үнэмлэхүй тушаал” (Categorical Imperative) дээр тулгуурладаг бөгөөд иргэн үүргээ ашиг сонирхлоос үл хамааран, шийтгэлээс айсандаа бус, зарчимдаа үнэнч байж биелүүлэх ёстой.

Харин Жереми Бентам, Жон Стюарт Милл нарын утилитаризм онол нь иргэний үүргийг нийгмийн нийт ашиг, сайн сайхныг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлдэл гэж тодорхойлдог. Аристотелийн сайн чанарын ёс зүйд иргэний үүрэг нь хувь хүний шударга ёс, энэрэл, хариуцлага зэрэг ёс суртахууны чанарыг төлөвшүүлж, амьдралд хэрэгжүүлэхэд оршдог бол Жон Финнис иргэний үүргийг практик ухаалаг чиг баримжаа, суурь үнэт зүйлстэй холбон тайлбарласан. Мөн Мартин Лютер Кинг “шударга хуульд захирагдах нь ёс суртахууны үүрэг боловч шударга бус хуульд үл захирагдах нь мөн ёс суртахууны үүрэг” гэж онцолж үүргийн ёс зүйн хэмжээсийг тодотгожээ.

Эрх зүйн онолын үүднээс үүргийг: Эрх зүйн онолд иргэний үүргийг Хууль зүйн позитивизм болон Эрх ба үүргийн харилцан хамаарлын (корреляцийн) онолоор тайлбарладаг.

Хууль зүйн позитивизмын онол: Энэхүү онол нь хууль бол төрөөс баталж, хүчин төгөлдөр болгосон бичмэл дүрэм бөгөөд түүнийг ёс суртахуунаас тусгаарлан ойлгох ёстой гэж үздэг. Жон Остин хуулийг “бүрэн эрхийн тушаал” гэж үзэж, иргэний үүргийг төрийн дээд эрх мэдлээс өгсөн тушаалыг дагаж биелүүлэх хууль ёсны үүрэг хэмээн ойлгосон. Ханс Кельзен “цэвэр эрх зүйн онол”-доо хуулийг шаталсан логик бүтэцтэй дүрмийн тогтолцоо гэж үзэж, иргэний үүргийг уг тогтолцоонд нийцүүлэн хууль сахих зан үйл гэж тодорхойлсон. Х.Л.А.Харт хуулийг анхдагч ба хоёрдогч дүрмийн нэгдэл гэж үзээд, иргэний үүрэг нь голчлон иргэдийн өдөр тутмын зан үйл, харилцааг шууд зохицуулдаг (татвар төлөх, хууль сахих) анхдагч дүрмийг дагаж мөрдөх зан үйл мөн хэмээн тодорхойлсон байна.

⁶ *Jonh Locke 's Two Treatises of Government*, <https://www.yorku.ca/comminel/courses/3025pdf/Locke.pdf>

⁷ Бунийхны Ц.Гомбосүрэн, *Ёс зүй*. (Улаанбаатар: Арвай принт, 2008), 67 дахь тал.

⁸ *Kant, Grundlegung zur Metaphysik der Sitten*, 1785.

Эрх ба үүргийн харилцан хамаарлын онолоор авч үзвэл:

Бид үүргийн тухай авч үзэхийн тулд юун түрүүнд эрхийг ойлгохын хэрэгтэй юм. Эрхийн талаар хоёр үндсэн ойлголт байдаг нь “сонголтын онол” болон “үр ашгийн буюу ашиг сонирхлын онол” юм. ... Сонголтын онолын дагуу эрх нь үндсэндээ үүргийн хамгаалалтын периметрээр бэхжүүлсэн эрх чөлөө, эрх мэдлээс бүрддэг.⁹ Сонголтын үр дүнтэй хамгаалалт нь эрх чөлөө, эрх мэдлийн үүргийн “хамгаалалтын периметрээр” хамгаалахыг шаарддаг.¹⁰

Үр ашгийн буюу ашиг сонирхлын онолын гол төлөөлөгч болох Ж.Бентам эрх нь ашиг хүртэх зорилготой байх ёстой хэмээн тайлбарладаг. ... Энэ онолоор товчхондоо эрх эдэлнэ гэдэг нь “бусдын үүргээс ашиг хүртэгч байх явдал юм” гэж тодорхойлдог. Энэ онол ёсоор тухайлбал, байгаль орчныг хамгаалах үүргийг төр болон иргэдэд ногдуулснаар бохирдол бууруулах, байгалийн тэнцлийг хадгалах, экологийн доройтлоос сэргийлэх зэрэг нийтийн ашиг бий болж, үүний шууд үр шимийг бусад бүх иргэд хүртдэг. Өөрөөр хэлбэл, нэг талын үүргийн биелэлт нь нөгөө талд амьдрах таатай орчин, эрүүл мэндийн хамгаалалт, байгалийн нөөцийн тогтвортой байдал зэрэг эрх хэлбэртэй ашиг болж эрүүл, аюулгүй орчинд амьдрах зэрэг эрх нь тухайн үүргийн биелэлтийн үр дүнд бий болох хамтын ашигт суурилсан, шууд бус шинжтэй эрхийн илэрхийлэл болж, эрх ба үүрэг нь шалтгаан-үр дагаврын уялдаа бүхий нэг цогц харилцаа болох нь харагдаж байна.

Ж.Бентам мета онолын үүднээс, гэхдээ өөрөөр аналитик схемийг санал болгож, зөвшөөрөх болон албадан хэрэгжүүлэх хуулиудыг ялгаж тодорхойлов. Эдгээр хоёр төрлийн хуулиас хоёр төрлийн хууль ёсны эрхүүдийг ялган авч үзсэн нь, хууль ёсны үүргүүд байхгүйгээс үүсэх хууль ёсны эрх чөлөө, хууль ёсны үүрэг хүлээлгэснээс үүсэх хууль ёсны эрхүүд байв.¹¹ Жишээлбэл, байгаль орчныг хамгаалах хууль ёсны үүргийг ногдуулаагүй бол иргэн байгаль орчныг хамгаалах болон хамгаалахгүй байж болох буюу тухайн харилцаанд саадгүй оролцох эрх чөлөөний орон зай үүсэх, нөгөөх нь байгаль орчныг хамгаалах хууль ёсны үүргийг ногдуулснаар тухайн үүргийг шаардах эрх бий болох буюу иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ шаардах эрх зүйн үндэслэлтэй болох үүргийн биелэлтээр баталгаажих бодит хамгаалалт болж хувирах юм.

Сонголтын онолын дагуу эрх нь үндсэндээ үүргийн хамгаалалтын периметрээр бэхжүүлсэн эрх чөлөө, эрх мэдлээс бүрддэг. Ж.Бентамын төлөөлдөг ашиг сонирхлын онолоор эрх эдэлнэ гэдэг нь “бусдын үүргээс ашиг хүртэгч байх явдал” юм. Жишээлбэл, байгаль орчныг хамгаалах үүргийг төр болон иргэдэд ногдуулснаар экологийн доройтлоос сэргийлэх нийтийн ашиг бий болж, үүний үр дүнд иргэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хэлбэртэй ашгийг шууд бусаар хүртдэг тул эрх ба үүрэг нь шалтгаан-үр дагаврын уялдаа бүхий нэг цогц харилцаа болдог. Бентамын аналитик

⁹ Ганболдын Амаржаргалан, Хувийн эрх зүй дэх эрх үүргийн бүтцийг харьцуулсан эрх зүй судлалын үүднээс тодорхойлох нь, Хууль зүйн ухааны докторын диссертаци, 2021, 63 дахь тал.

¹⁰ Дам эшлэв: Ганболдын Амаржаргалан, Хувийн эрх зүй дэх эрх үүргийн бүтцийг харьцуулсан эрх зүй судлалын үүднээс тодорхойлох нь, Хууль зүйн ухааны докторын диссертаци, 2021, 62-63 дахь тал

¹¹ Дам эшлэв: Ганболдын Амаржаргалан, Хувийн эрх зүй дэх эрх үүргийн бүтцийг харьцуулсан эрх зүй судлалын үүднээс тодорхойлох нь, Хууль зүйн ухааны докторын диссертаци, 2021, 58 дахь тал.

схемээр хууль ёсны үүргүүд байхгүйгээс үүсэх хууль ёсны эрх чөлөө болон хууль ёсны үүрэг хүлээлгэснээс үүсэх хууль ёсны эрхүүд гэж ялгардаг байна.

Иргэний Үүргийг онолын үзэл хандлагад тулгуурлан хэд хэдэн загвар болон ангилалд авч үзэх бий. Тухайлбал,

- **Зайлшгүй биелүүлэх эсэх шинжээр нь:** Төрөөс заавал биелүүлэхийг шаарддаг, албадлагын механизмтай уялдсан *Хууль зүйн үүрэг* (татвар төлөх, цэргийн алба хаах) болон иргэний ухамсар, нийгмийн итгэлцэлд тулгуурласан *Сайн дурын буюу иргэний оролцооны үүрэг* (сонгуульд оролцох, сайн дурын ажил хийх).

- **Субъектив оролцооны түвшинээр нь:** Шууд оролцоо, санаачилга шаарддаг *Идэвхтэй иргэний үүрэг* (сонгуульд санал өгөх, нийтийн бодлогод нөлөөлөх) болон хязгаарлалтад суурилсан *Идэвхгүй иргэний үүрэг* (бусдын эрхийг зөрчихгүй байх, хууль сахиу).

- **Норматив эх сурвалжаар нь:** Нийгмийн хүлээлтэй холбоотой *Ёс суртахууны үүрэг* (шударга байх, бусдад туслах) болон төр, байгууллагатай харилцахад үүсдэг *Институцийн үүрэг*.

- **Хэрэгжих хүрээгээр нь:** Ойрын орчинд хэрэгжих *Хувийн үүрэг* (хүүхдээ хүмүүжүүлэх) болон нийгмийн түвшинд хэрэгжих *Нийтийн үүрэг* (байгаль орчныг хамгаалах).

- **Агуулгаар нь:** Улс төрийн, нийгмийн, эдийн засгийн, экологийн үүрэг.

- **Шинж чанараар нь:** Заавал хэрэгжүүлэх *Эерэг үүрэг* болон хийхээс зайлсхийх буюу татварлах *Сөрөг үүрэг*.

- **Хууль зүйн шинжээр нь:** Үндсэн хуульд суурилсан, төрийн албадлагаар баталгаажсан *Үндсэн үүрэг* (constitutional duty) болон иргэний ёс суртахуун, сайн дурын биелэлтэд суурилсан, хариуцлагын уян хатан шинжтэй *Журамт үүрэг* (statutory duty).

- **Харилцан хамаарлаар нь:** Тодорхой эрхтэй шууд уялддаг *Харилцан хамааралтай* (correlative) үүрэг болон *Бие даасан үүрэг* (non-correlative).

Үүнээс гадна иргэний үүрэг нь улс төрийн үзэл суртлын чиг баримжаанаас хамаарч ялгаатай авч үзэгддэг. Барууны (либерал/консерватив) хандлагад үүргийг хувь хүний ухамсар, сайн дурын хариуцлага, нийгмийн соёлд тулгуурласан урамшууллын аргаар хэрэгжүүлэх зүйл гэж үздэг бол Зүүний (социалист/социал-демократ) хандлага нь иргэний үүргийг нийтийн ашиг, төрийн шаардлагад нийцсэн хууль эрх зүй, хяналт зохицуулалтын аргаар заавал хэрэгжүүлэх зүйл гэж үздэг байна.

Иргэний үүргийн ангилал нь зөвхөн ангилал зүйн техник асуудал бус, харин эрх зүйт төрийн мөн чанар, ардчилсан засаглалын тогтвортой байдлыг тайлбарлах онолын суурь категори юм. Түүнийг олон шалгуураар ангилах нь иргэний оролцооны чанарыг үнэлэх, эрх үүргийн тэнцвэрийг тодорхойлох, төрийн бодлогын чиглэлийг оновчтой тодорхойлох арга зүйн үндэс болдог. Тиймээс ч хууль зүйн шинжлэх ухаанд “ач холбогдол бүхий байдал”¹² нь хуулийн хэм хэмжээг түүний үнэт зүйл, нийгмийн зорилго, эрх зүйн чиг үүргийн дагуу ангилахыг шаарддаг.

¹² Кельзенийн шаталсан норм, Хартын дүрмийн ангилал, Дворкины зарчмын жингийн онол зэрэгт тулгуурлан хөгжссөн системийн ойлголт.

Иймд иргэний үүргийн ангиллыг бүсчилсэн, олон түвшний хандлагаар судлах нь зөвхөн онолын төдийгүй бодлого, эрх зүйн зохицуулалтын түвшинд чухал ач холбогдолтой бөгөөд энэ нь иргэний оролцоог идэвхжүүлэх, эрх, үүргийн тэнцвэрийг хангах, ардчилсан засаглалын чанарыг сайжруулахад чиглэсэн суурь арга зүйн үндэс болдог.

Орчин үеийн чиг хандлага ба онолын шинэ хандлагууд:

Иргэний үүргийн философийн шинэ чиг хандлага нь уламжлалт либерализм, позитивизм, марксизм зэрэг сонгодог онолуудаас давж гарч, даяаршил, технологийн хөгжил, хүний эрхийн өргөжилт, байгаль орчны хямрал болон олон төвт засаглалын нөхцөлд үүргийн ойлголтыг дахин тайлбарлаж буй орчин үеийн онолын хандлагуудын цогц юм.¹³ Эдгээр хандлага нь иргэнийг зөвхөн хууль сахигч субъект бус, нийгмийн харилцааны идэвхтэй оролцогч, хариуцлагатай түнш гэж үздэг.

Орчин үеийн судалгаанд иргэний оролцооны онол, харилцан ойлголцлын онол, экологийн иргэншлийн онол зэрэг шинэ хандлагууд хөгжиж байна.

Ардчиллын оролцооны болон харилцан ойлголцлын онол: Германы сэтгэгч Юрген Хабермас “Үндсэн хуульт ардчиллын онол” болон харилцан ойлголцлын онолоороо иргэний үүргийг зөвхөн захирагдах бус, харилцан ойлголцолд тулгуурласан нийгмийн харилцаа, нийтийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох харилцан үйл ажиллагаа гэж үзсэн. Мөн Кэрл Пэйтмэн (Theory of Participatory Democracy) иргэний үүргийг ардчиллын чанарын үндэс гэж үзээд, энэ нь зөвхөн хууль сахих бус, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, хамтын хариуцлага хүлээх ёс суртахууны илэрхийлэл мөн гэж тодорхойлжээ.

Хүний эрх ба хариуцлагын онол (Theory of Human Rights and Responsibility Theory): Жон Роулс, Амаргья Сен, Т.Х.Маршалл нарын судлаачид хүний эрхийг үүрэг, хариуцлагатай уялдуулан хэрэгжүүлэх ёстой институцийн тогтолцооны нэг хэсэг¹⁴ гэж үзсэн. Т.Х.Маршалл (Citizenship and Social Class) иргэний, улс төрийн, нийгмийн эрхийг зэрэг хөгжүүлэх нь үүргийн хариуцлагыг баталгаажуулж, шударга ёсны үндэс болно¹⁵ гэж тодорхойлсон бөгөөд иргэний үүрэг нь “эрхээ эдлэхийн тулд үүргээ ухамсарлах” зарчимд суурилсан эрхийн бодит хэрэгжилтийн урьдчилсан нөхцөл болдог байна.

Нийгэм хөгжихийн хэрээр иргэний эрх, үүргийг агуулга цар хүрээ өргөжин түүнийг дагаад цахим орчны хөгжлийн үр дүнд иргэний үүргийг цахим ёс зүй, мэдээллийн үнэн зөв байдал, хувийн мэдээллийн хамгаалалт болон хариуцлагатай хэрэглээтэй холбон тайлбарлах шинэ чиг хандлагууд бий болж байна.

¹³ Mila Versteeg, Adam Chilton, Erensu Altan, “Constitutional Duties” (2024), p52 https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=5104694

¹⁴ John Rawls, The Law of Peoples (Harvard University Press 1999) 65–68, 79–81. <https://mercaba.org/SANLUIS/Filosofia/autores/Contempor%C3%A1nea/Rawls/The%20Law%20of%20Peoples.pdf>

¹⁵ T.H. Marshall's "Citizenship and Social Class" (1950), <https://s3.us-west-1.amazonaws.com/p-library/books/b22baab2fe1f967c2346fb58c091c630.pdf>

4. Дүгнэлт

Иргэний үүрэг нь ганц нэг онолоор хязгаарлагдахгүй, философи, ёс зүй, эрх зүй, улс төрийн олон парадигмын огтлолцолд бүрэлдсэн олон талт ойлголт гэж үзэх зүйтэй юм. Нийгмийн гэрээний онол үүргийг төрийн легитим байдлын үндэс гэдэг бол ёс суртахууны онолууд хүний дотоод ухамсартай, хууль зүйн позитивизм нь институцийн норматив хэм хэмжээтэй холбон тайлбарладаг. Орчин үеийн чиг хандлагад үүрэг нь идэвхтэй оролцоо, хүний эрхийн бодит баталгаа, экологийн болон дижитал ухамсарт хамтын хариуцлагын хэлбэрт шилжин өргөжиж байна. Иймд иргэний үүргийг эрх зүйн ердийн үүрэг гэж тусгаарлан ойлгохоос илүүтэй эрх, үүргийн харилцан хамаарал, ёс суртахууны ухамсар, улс төрийн оролцоо, нийгмийн хариуцлагыг нэгтгэсэн нэгдмэл тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзэх нь онол, практикийн хувьд чухал ач холбогдолтой юм.

5. Эх сурвалж

- *Монгол Улсын Үндсэн хууль*
- *Монгол хэлний их тайлбар толь.* <https://mongoltoli.mn/>
- *Ганболдын Амаржаргалан. Хувийн эрх зүй дэх эрх үүргийн бүтцийг харьцуулсан эрх зүй судлалын үүднээс тодорхойлох нь, Хууль зүйн ухааны докторын диссертац, 2021 он*
- *Бунийхны Ц.Гомбосүрэн, Ёс зүй. 2008 он*
- *Mila Versteeg, Adam Chilton, Erensu Altan, "Constitutional Duties" University of Chicago Law School, Public Law & Legal Theory Research Paper No. 25-15* https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=5104694#
- *Cicero, De Officiis, I.4.*
- *T.Hobbes's Leviathan,* <https://historyofeconomicthought.mcmaster.ca/hobbes/Leviathan.pdf>
- *Jonh Locke 's Two Treatises of Government,* <https://www.yorku.ca/comninel/courses/3025pdf/Locke.pdf>
- *Kant, Grundlegung zur Metaphysik der Sitten, 1785*
- *John Rawls, The Law of Peoples (Harvard University Press 1999) 65–68, 79–81.* <https://mercaba.org/SANLUIS/Filosofia/autores/Contempor%C3%A1nea/Rawls/The%20Law%20of%20Peoples.pdf>
- *T.H. Marshall's "Citizenship and Social Class" (1950),* <https://s3.us-west-1.wasabisys.com/p-library/books/b22baab2fe1f967c2346fb58c091c630.pdf>